

## Гарчиг

<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>4</b>
1.1.Төслийн ерөнхий мэдээлэл	4
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн байршил	6
1.4 Тоног төхөөрөмж, хүчин чадал	6
1.5 Төслийн дэд бүтэц, хог хаягдал	18
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>20</b>
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил	20
2.2 Физик-газарзүйн нөхцөл	20
2.3 Цаг уур, Уур амьсгалын нөхцөл	22
2.4 Агаарын чанар	22
2.4 Гадаргын ус	23
2.5 Хөрсөн бүрхэвч	23
2.6 Ургамлан нөмрөг	26
2.7 Тусгай хамгаалалттай газар нутаг	27
2.8 Түүх, соёлын өв	28
2.9 Нийгэм, эдийн засаг	29
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>31</b>
3.1 Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл	31
3.2 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	31
3.3 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	31
3.4 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл	31
3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл	31
3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл	32
3.7 Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	32
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ</b>	<b>33</b>
4.1 Зорилго	33
4.2 Хамрах хүрээ:	33
<b>ТАВДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	<b>34</b>
<b>ЗУРГААДУГААР БҮЛЭГ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	<b>35</b>
<b>ДОЛООДУГААР БҮЛЭГ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	<b>35</b>
<b>НАЙМДУГААР БҮЛЭГ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	<b>35</b>
<b>ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	<b>36</b>
<b>АРАВДУГААР БҮЛЭГ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	<b>36</b>
<b>АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	<b>37</b>
<b>АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР</b>	<b>38</b>
<b>АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	<b>39</b>

**АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД  
ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 40**

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1 Талбайн солбицол .....	6
Хүснэгт 2 Хэрэглэх усны тооцоо .....	18
Хүснэгт 3 Өмнөговь аймгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужлал .....	21
Хүснэгт 4 Агаарын чанарын хэмжилтийн дүн .....	22
Хүснэгт 5 Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ .....	24
Хүснэгт 6 Хөрсний агрохимийн үндсэн үзүүлэлтүүд .....	24
Хүснэгт 7 Хөрсний механик бүрэлдэхүүн .....	25
Хүснэгт 8 Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж .....	25
Хүснэгт 9 Төслийн талбай орчмын ургамлын бүлгэмдэл, төлөв байдал .....	26
Хүснэгт 10 Ханбогд сумын хүн амын тоо /багаар/.....	30
Хүснэгт 11 Өрхийн тоо.....	30
Хүснэгт 12 Малтай өрхийн тоо .....	30
Хүснэгт 13 Малын тоо, /мян.төг/.....	30
Хүснэгт 14 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл дүн 2026 он .....	33
Хүснэгт 15 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	34
Хүснэгт 16 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу хийх арга хэмжээ .....	35
Хүснэгт 17 Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ.....	35
Хүснэгт 18 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ .....	36
Хүснэгт 19 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ .....	36
Хүснэгт 20 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ .....	37
Хүснэгт 21 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	39

**Зургийн жагсаалт**

Зураг 1 Төслийн талбай.....	5
Зураг 2 Талбайн хаалга хэсэг.....	7
Зураг 3 Талбайн үүд хэсэг.....	7
Зураг 4 Оффисын байр .....	8
Зураг 5 Оффисын байр .....	8
Зураг 6 Ажилтны амралтын өрөө .....	9
Зураг 7 Ажилтны амралтын өрөө .....	9
Зураг 8 Оффисын амрах хэсэг .....	10
Зураг 9 Ажилтны амрах өрөө.....	10
Зураг 10 Ажилтны хоолны газар.....	11
Зураг 11 Ажилтны хоолны газар.....	11
Зураг 12 Автомат жингийн удирдлагын байр .....	12
Зураг 13 Хяналтын камер .....	12
Зураг 14 Хяналтын камер .....	13
Зураг 15 Талбайн автомат жин.....	13
Зураг 16 Авто зогсоол .....	14
Зураг 17 Гинжит экскаватор.....	14
Зураг 18 Ангилсан дахивар .....	15
Зураг 19 Ангилах боломжгүй хогийн сав.....	15

Зураг 20 Аюултай хог хаягдлын цэг.....	16
Зураг 21 Гадаах нойл-урдаасаа /бетонон кольцо суурилуулсан/ .....	16
Зураг 22 Гадаах нойл-хойд талаасаа /бетонон кольцо суурилуулсан/.....	17
Зураг 23 Ногоон байгууламж.....	17
Зураг 24 Гаалийн хяналтын талбай.....	18
Зураг 25 Төслийн талбайн байршил .....	20
Зураг 26 Монгол орны байгалийн бүс бүслүүрийн зураг (Ш.Цэгмид, 1969 он .....	21
Зураг 27 Төслийн талбай орчмын усны сав газрын зураг.....	23
Зураг 28 Төсөл хэрэгжих талбай орчмын хөрсөн бүрхэвчийн хэв шинж.....	24
Зураг 29 Хөрсний дээж авсан цэгийн байршлын зураг.....	25
Зураг 30 Төсөл хэрэгжих талбай орчмын ургамлан нөмрөгийн хэв шинж.....	26
Зураг 31 Төсөл хэрэгжих талбайн орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутаг.....	27
Зураг 32 Төсөл хэрэгжих талбай орчмын Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг.....	28
Зураг 33 Ханбогд сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын байршил .....	29

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Тус компани нь 2007, 2018, 2022 онуудад БОННУ-ний тайланг БОУАӨЯ-аар оруулан батлуулж байсан. 2020 оны 11 сараас Гаалийн Хяналтын талбайн зориулалтаар 40 га талбайд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Нүүрс хадгалах гаалийн хяналтын талбайг 40 га газарт стандартын дагуу төхөөрөмжилж салхины хаалт бүхий хашаа, гэрэлтүүлэг, хяналтын камер, зориулалтын машин пүүлэгч автомат жин, зэрэг тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Компаниудтай байгуулсан гэрээгээр нүүрсний импорт, экспортын үйл ажиллагааг стандартын дагуу явуулж одоогийн байдлаар нийт 30 гаруй ажилтантай ажлын болон амрах байрыг бүрэн тохижуулж ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгаа, цалин хөлс зэрэг бусад асуудлыг кемпийн дотоод журамд тусган ажиллаж байна. Одоогийн байдлаар төслийн 2022 онд батлагдсан БОННУ тайлангийн дагуу 2022, 2023, 2024 онуудад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОУАӨЯ-аар батлуулан, биелэлтийг тайлагнасан. Тус 2026 онд 4 дахь жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах 2 хэсгээс бүрдэнэ.

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тусган төлөвлөв.

### 1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

<b>Төслийн нэр:</b>	“Гаалийн хяналтын талбай”
<b>Төсөл хэрэгжүүлэгч:</b>	“Пүшинмон” ХХК
<b>Улсын бүртгэлийн дугаар:</b>	9011402049 (Регистрийн дугаар: 2889625)
<b>Төсөл хэрэгжих байршил:</b>	Өмнөговь аймгийн Ханбогд сум, Цагаан хадны гаалийн хяналтын бүс.
<b>Хаяг:</b>	Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 -р баг, Далан, музей 3., Утас: 99995225

#### Байгууллагын танилцуулга:

Тус компани нь Гаалийн хяналтын талбайд 700 мянган тонн нүүрсийг ачиж буулгах хүчин чадалтай, талбайн ул нь ямар ч сул шороогүй баруун талын засмал, зүүн талын шороон замтай холбогдсон ачилт буулгалтын дараалал үүсэхээргүй зохион байгуулагдсан.

Салхины хаалт нь 10 метр өндөр 1800 метрийн өргөнтэй 800 метрийн урттай бетон суурь, төмөр баганаар бэхлэгдсэн хашаатай. БНХАУ-н Шэнда үйлдвэрийн 50 кг- 200 тонн хүртэлх даацтай 3 автожин, ачилт буулгалтад зориулагдсан 10-н дугуйт ачигч, 1 гинжит экскаватор тус тус ашиглагдаж байна.



Зураг 1 Төслийн талбай

Тус компани нь сум нутгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмэр;

- Өмнөговь аймгийн нутгийн удирдлагын ордны ашиглалт;
- Өмнөговь аймгийн ДЦС-ын зуух засварлалт;
- Тавантолгой - Гашуунсухайт хүртэл хатуу хучилттай сайжруулсан замын ажил;
- Өмнөговь аймгийн хүүхдийн ордон, Гашуун сухайт боомтын тохижилт, Цогтцэций, Хүрмэн сумдын байгалийн гамшгийн тохиолдолд зориулж бодитой хувь нэмэр оруулж байна.

Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг дараах схемээр харуулав.




### 1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн байршил

Тус гэрчилгээ нь 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр шинэчлэгдэж 000015219 тоот гэрчилгээний дугаартай. Тухайн талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутагт хамаарна.

Хүснэгт 1 Талбайн солбицол

№	Солбицол	
1	42°36'07.6''	107°31'25.6''
2	42°36'21.4''	107°31'12.0''
3	42°36'29.9''	107°31'27.2''
4	42°36'37.0''	107°31'38.6''
5	42°36'23.6''	107°31'52.0''



Зураг 1 Төслийн талбайн байршил

### 1.4 Тоног төхөөрөмж, хүчин чадал

Пүшинмон ХХК нь өөрийн эзэмшил талбайд тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулах баазтай, засвар үйлчилгээний хэсэг, ажилтан амрах амралтын байр, оффисын байр нүүрс ачилт буулгалтын талбай нь 750м урт, 10м-ийн өндөртэй стандарт хашаатай. Хоногт 150-200 машин нүүрс буулгах, ачих талбай, 260 ачааны машин зогсох зогсоолтой.

- ZTE маркийн ачигч ковш 4 ш,
- ХК3190-А9 загвар бүхий авто жин пүүлэлт 2 ш,
- Dell маркийн суурин компьютер 2 ш,
- принтер 3 ш зэрэг тоног төхөөрөмжтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг 2 Талбайн хаалга хэсэг



Зураг 3 Талбайн үүд хэсэг



*Зураг 4 Оффисын байр*



*Зураг 5 Оффисын байр*




Зураг 6 Ажилтны амралтын өрөө




Зураг 7 Ажилтны амралтын өрөө



Зураг 8 Оффисын амрах хэсэг



Зураг 9 Ажилтны амрах өрөө



*Зураг 10 Ажилтны хоолны газар*




*Зураг 11 Ажилтны хоолны газар*


## ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН АЖЛЫН БАЙР




Зураг 12 Автомат жингийн удирдлагын байр



Зураг 13 Хяналтын камер



Зураг 14 Хяналтын камер



Зураг 15 Талбайн автомат жин



Зураг 16 Авто зогсоол



Зураг 17 Гинжит экскаватор



Зураг 18 Ангилсан дахивар



Зураг 19 Ангилах боломжгүй хогийн сав



Зураг 20 Аюултай хог хаягдлын цэг



Зураг 21 Гадаах нойл-урдаасаа /бетонон кольцо суурилуулсан/



*Зураг 22 Гадаах нойл-хойд талаасаа /бетонон кольцо суурилуулсан/*



*Зураг 23 Ногоон байгууламж*



Зураг 24 Гаалийн хяналтын талбай

### 1.5 Төслийн дэд бүтэц, хог хаягдал

Барилга, байгууламж: Тус төслийн хүрээнд 40 га талбайд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс кемпийн хэсэг 800м<sup>2</sup> орчим талбайг хамарч байрладаг. Кемп байрлах талбайд оффисын байр 1, ажилчдын амралтын 1 давхар жижиг байр, харуулын байр, автомат жингийн удирдлагын хэсэг, харуулын байр тус тус объектууд байдаг.

Цэвэр, бохир усны хангамж: Кемпийн ажилтны ахуйн хэрэглээний усыг гэрээний үндсэнд зөвөрлөн хангадаг. Худгийн эзэмшигч нь Ханбогд сумын 1 дүгээр багийн Цагаанхаданд оршин суух иргэн (Б.Цэнгэл /РД: УХ93110275/-) тэй гэрээлсэн.

Унд ахуйн усны хэрэглээг нормын дагуу тооцож дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2 Хэрэглэх усны тооцоо

№	Ус ашиглах төрөл	Хэмжих нэгж	Норм /А/301/	Төслийн хүчин чадал	Хоногт хэрэглэх ус	Хоногт хэрэглэх ус, м <sup>3</sup> /хон
1	Ажилтан /оффист/	ажилтан/л	50	28	1400	1.4
2	Цэцэрлэг, зүлэг ногоо услах	м <sup>2</sup>	4	300	1200	1.20
<b>Нийт усны хэмжээ</b>						<b>2.6</b>

Эх сурвалж: 2015.07.30 А-301 тоот тушаал “Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”)

Цахилгаан хангамж: Цахилгаан хангамжийг төвийн шугам буюу “ӨБЦТС” ТӨХК-тай гэрээлэн цахилгаан хэрэглээгээ хангадаг.

Дулаан хангамж: Дулааны хангамжийг нам даралтат уурын зуухаар шийдвэрлэнэ.

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг хог хаягдлын ангилал, кодчиллын дагуу дараах хүснэгтэд тусгав.


Хүснэгт 3. Хог хаягдлын төрөл, ангилал, код

№	Өнгө	Ангилал	Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын бүлгийн код	Хог хаягдлын төрлийн код	Аюулын зэрэглэл	Тайлбар	
							Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрөл
1		Хуванцар сав, уут	Ус ундааны хуванцар сав, гялгар уут	20	20 01 27	-	Ангилж цуглуулсан хог хаягдал (15 01 -ээс бусад)	Хуванцар
2		Лааз, шил	Төмөр лааз, будгийн сав, газны сав	20	20 01 28	-		Металл
3		Цаас	Бичгийн цаас, Картон цаас	20	20 01 01	-		Цаас, картон
			Шил	20	20 01 02	-		Шил
4		Төмөр	Машины хаягдал сэлбэг, төмөр	20	20 01 28	-		Металл
5		Ахуйн хог хаягдал	Дахин боловсруулах боломжгүй	20	20 03 01	-	Бусад ахуйн хог хаягдал	Холимог ахуйн хог хаягдал
6		Аюултай хог хаягдал	Засварын хэсгээс гарах аюултай хог хаягдал /батарей/ Н6.1; Н12; С3	16	16 06 05	-	Батарей, аккумулятор	Бусад төрлийн батарей
7		Тос, тослох материал	Тос тослох материалын хаягдал	13	13 01 01	А	Гидравлик тосны хаягдал	Полихлорт бифенил (PCBs) агуулсан гидравлик тос
8		Бохир ус	Ахуйн бохир ус	19	19 09 99	-	Ахуйн хэрэглээний болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны боловсруулалтаас гарах хаягдал	Тусгайлан заагдаагүй бусад хаягдал

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил


“Пүшинмон” ХХК -ийн нүүрс ачиж буулгах, гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийн зүүн урд хэсэгт улсын хилээс хойш 20 гаруй км -т Цагаан хадан худгаас баруун хойш 3.5 км–т 40 га газарт байрлаж байна. Ханбогд сум нь урд талаараа БНХАУ-тай хил залгаа Гашуун сухайт боомттой, баруун талаараа Баян-Овоо сум, хойд талаараа Манлай сум, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сумдтай хил залгаа оршино.



Зураг 25 Төслийн талбайн байршил

### 2.2 Физик-газарзүйн нөхцөл

Өмнөговь аймаг нь 165.0 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутгийн хэмжээгээрээ Монгол улсдаа хамгийн томд ордог аймаг юм. Аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны Байгалийн бүс бүслүүрийн ангиллаар Говийн болон Цөлийн бүсэд багтах бөгөөд дунджаар д.т.д. 1300-1600 м өндөрт оршино. Энд Алтайн нурууны үргэлжлэл Гурван сайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтан уул, Гилбэнт зэрэг д.т.д. 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий.



Зураг 26 Монгол орны байгалийн бүс бүслүүрийн зураг (Ш.Цэгмид, 1969 он)

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг геологийн бүтэц, уур амьсгал, хотгор гүдгэр, ус зүй, хөрс ба ургамалшил, амьтны аймгийн хам бүрдэл, тэдгээрийн хоорондын ялгаа, харилцан үйлчлэлийн ижил төстэй нөхцөлүүдээр нь 3 муж, 5 тойрог болгон мужилсан байдаг.

Хүснэгт 3 Өмнөговь аймгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужлал

№	Мужийн нэр	Тойргийн нэр	Талбай, га
1	Говийн алтайн уулсын муж	Их, Бага Богдын уулсын тойрог (Г-5)	285,362.4
		Гурвансайхан уулсын тойрог (Г-6)	2,237,586.4
2	Алтайн өвөр говийн цөлийн муж	Алтайн өвөр говийн тойрог (Г-8)	4,660,120.5
3	Дорнод говийн цөлөрхөг муж	Дорнод говийн хойд хэсгийн тойрог (Г-9)	3,263,476.8
		Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10)	6,091,501.0
-	<b>Нийт</b>		<b>16,538,047.0</b>

“Пүшинмон” ХХК-ийн төслийн талбай байрлах Ханбогд сум нь Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10)-т хамаарч байна.

Ханбогд сум нь газарзүйн байршлын хувьд Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг ба Ханбогд уулын орчимд орших говийн намхан толгодоос тогтдог. Тухайн сум нь говийн бүсдээ харьцангуй өндөрт тооцогдох уулуудтай ба үүнд Ханбогд уул (д.т.д 1350 м), Бумбат задгайн хяр (д.т.д 1233.3 м), Жавхлант уул 1295 м (д.т.д), Далайн Дуулга (д.т.д 1266 м) зэрэг уулс орно.

### 2.3 Цаг уур, Уур амьсгалын нөхцөл

Өмнөговь аймаг нь байгаль цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө -20-30 градус хүртэл хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь 30-38 градус, салхины хурд 5-15 м/сек, заримдаа 34-45 м/сек хүрдэг.

Өмнөговь аймгийн нутагт уул нуруу, говь хонхор, газрын гадаргын хэв шинж олон янз учраас байгалийн ба уур амьсгалын нөхцөл нь хэд хэдэн муж болж хуваагдах онцлогтой байна. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг уур амьсгалын 3 мужид хувааж болж байна. Үүнд:

- Хуурай сэрүүвтэр муж
- Хуурай дулаавтар муж
- Нэн хуурай дулаан муж

**Нарны гийгүүлэлт:** Манай орны нутгаар жилд дунджаар нарны гийгүүлэхийн үргэлжлэх хугацаа 2800-3600 цагийн хооронд хэлбэлзэж байдаг ба нийлбэр цацрагийн хэмжээ жилд 5237.5-6285 мДж/м<sup>2</sup> байдаг.

Ханбогд сумын орчмоор агаарын температурын ОЖД нь 7.9<sup>0</sup>С бөгөөд сүүлийн таван жилийн дундаж утга 8.5<sup>0</sup>С, температурын хандлагын өөрчлөлтийг боловсруулж үзэхэд: сүүлийн жилүүдэд агаарын дундаж температурын утга ОЖД-аас 0.6<sup>0</sup>С-р дулаарсан ажиглагдаж байна.

Ханбогд сумын орчмоор ОЖ-ийн дунджаар жилдээ 109.2 мм хур тунадас ордог. Сүүлийн зургаан жилийн дунджаар 132.5 мм хур тунадас орсон байгаа нь ОЖ-ийн дунджаас 23.3 мм орчмоор ахиу хур бороо сүүлийн жилүүдэд орсон байна. Сүүлийн зургаан жилийн тунадасны хэмжээ нэмэгдэх болсон нөхцөл нь 2018 оны 7, 8 дугаар саруудад болон 2021 оны 8 дугаар сард хур борооны их байсантай холбоотой байна.

**Салхины горим:** Ханбогд сумын салхины жилийн дундаж хурд 4.5 м/с буюу салхины хурд ихтэй байдаг бөгөөд олон жилийн өөрчлөлтийн хандлагыг харахад салхины хурд ялимгүй нэмэгдэх хандлагатай байна.

### 2.4 Агаарын чанар

“Пүшинмон” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Гаалийн хяналтын талбай” төслийн орчимд агаар дахь тоосжилт, агаарын чанарын индекс болон дуу чимээний түвшнийг зөөврийн багажуудын тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ.

Дээрх хэмжилт судалгаанд агаарын тоосжилт, чанарыг Temtop LKC-1000, дуу чимээг MS6300 Environment Multimeter багажуудыг ашигласан болно.

Хүснэгт 4 Агаарын чанарын хэмжилтийн дүн

№	Байршил	AQI	PM 2.5 (ug/m <sup>3</sup> )	PM10 (ug/m <sup>3</sup> )	НСНО (mg/m <sup>3</sup> )	TVQC (mg/m <sup>3</sup> )	Байршил
1	1-р цэг	97	31.8	60.6	0.44	1.35	Төслийн талбайд

Төслийн талбайд хийсэн хэмжилтийн дүнгээр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 17 -ны өдрийн А-327 тоот тушаалын 1 дүгээр хавсралтад заасан Агаарын чанарын индексийн дүн, агаарын чанарын ангиллаар хэвийн, Агаарын чанар шаардлага хангах боловч, зарим бохирдуулах бодисын нөлөөлөлд хэт мэдрэг хүмүүс өртөж болно.

**Төслийн талбайн орчимд хийж гүйцэтгэсэн тоосжилтын хэмжилт:** Агаарын тоосжилтын хэмжилтийн явцад PM10 60.6 мг/м<sup>3</sup>, PM2.5 31.8 мг/м<sup>3</sup> утгатай гарч байв.

Агаарын чанарт хэмжилт хийсэн цэгийн хувьд агаарын чанарын стандарт MNS 4585 : 2025

-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага гарч байв.


Төслийн талбайд нүүрс тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагаа эхлээгүй, хөл хөдөлгөөн багатай, салхи ихтэй байв.

## 2.4 Гадаргын ус

Өмнөговь аймаг нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагшаа урсацгүй ай савын бүсэд багтдаг.

Ханбогд сумын нутаг дэвсгэр нь бүхэлдээ Галба-Өөш-Долоодын говийн сав газарт хамаарагдана. 2020 оны усны тоо бүртгэлээр Галба-Өөш-Долоодын говийн сав газарт нийтдээ 32 булаг, 86 нуур, тойром, 182 худаг бүртгэгдсэн байна.

“Пүшинмон” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Гаалийн хяналтын талбай” төслийн талбайн орчимд задгай урсах гол горхи, булаг шанд байхгүй, түр зуурын усны үйл ажиллагаагаар үүссэн гуу жалга хуурай сайр зэрэг үүссэн байдаг. Төслийн талбайн эргэн тойронд ил уст цэг байхгүй байна.



Зураг 27 Төслийн талбай орчмын усны сав газрын зураг


## 2.5 Хөрсөн бүрхэвч

Ханбогд сум нь говийн бор хөрс, цөлийн бор саарал хөрсний бүст хамрагдана. Тус сумын нутаг дэвсгэрийн хөрс нь үндсэндээ сул хөгжилтэй, говийн сийрэг тархсан (бүрхэц 8- 25 %) ургамлан нөмрөгийн дор бүрэлдэн тогтсон хөрс зонхилно. Хөрсөн дэх органик бодисын агууламж нь 1.0 хувиас бага, сул шүлтлэг, шүлтлэг чанар нь кальци, магнийн катионуудын концентрациас хамаарч, хөрсний давхарга бүрд харилцан адилгүй байна.

“Пушинмон” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Гаалийн хяналтын талбай” төслийн талбайд Цөлийн мараалаг бор саарал хөрс тархсан байна.

Хүснэгт 5 Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ

№	Хөрсний нэр	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Цөлийн мараалаг бор саарал хөрс	40.0	100.0
	<b>Нийт</b>	<b>40.0</b>	<b>100.0</b>




Зураг 28 Төсөл хэрэгжих талбай орчмын хөрсөн бүрхэвчийн хэв шинж

Цөлийн бор саарал хөрс: Жинхэнэ цөлийн хөрс манай орны урд хэсгээр тархаж улсын бүх нутгийн 9.3 %-тай тэнцэх талбайг эзэлнэ. Түүний 6.9 % нь хөндий хотгор, тал газраар, үлдсэн 2.4 % нь уул толгодоор тархана. Хөрсний дээжийн лабораторийн задлан шинжилгээний дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6 Хөрсний агрохимийн үндсэн үзүүлэлтүүд

№	Гүн, см	pH	ЦДЧ ds/m	Давс%	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	Солилцох суурь, мг/экв			Шим тэжээлийн бодисууд, мг/100г		
							Ca+Mg	Ca	Mg	NO <sub>3</sub>	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
1	0-10	8.64	1.820	0.90	0.19	1.98	21.8	13.4	8.4	0.24	1.5	14



Зураг 29 Хөрсний дээж авсан цэгийн байршилн зураг

Хүснэгт 7 Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ /мм, хувиар/						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	0-10	25.5	37.1	17.1	4.3	4.8	11.2	20.3

Хүснэгт 8 Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хөрсний хүнд металлын агууламж, мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
1	0-10	66.34	0.0	3.27	87.42	1.56	8.47
<b>Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019</b>							
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/		150.0	3.0	100.0	300.0	150.0	100.0
Хортой агууламж /MNS 5850:2019/		1000.0	10.0	500.0	600.0	400.0	500.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/		1800.0	20.0	1200.0	1000.0	1500.0	1000.0


Төслийн талбайн хөрсний өнгөн хэсэгт зарим хүнд металлуудын агууламжийг /MNS ISO 11466:2007/атом шингээлтийн спектрометрээр шинжилж MNS 5850:2019 стандарттай харьцуулахад 0-10 см-ийн гүнээс авсан дээжид хар тугалга 3.27 мг/кг, цайр 87.42 мг/кг, зэс 8.47 мг/кг, хром 1.56 мг/кг, кадмий илрээгүй байна.

Шинжилгээний хариунаас харахад Хүлцэх агууламж /MNS5850:2019/ стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

## 2.6 Ургамлан нөмрөг

Ханбогд сумын нутгийн хойд хэсэг нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог, Улсын хил дагуух өмнөд хил нь Алшаа говийн цөлийн тойрогт тус тус хамрагдана.

“Пүшинмон” ХХК-ийн хэрэгжүүлж буй Гаалийн хяналтын талбай төслийн орчимд Чулуурхаг баглуурт, баглуур-бударганат бүлгэмдэлийн ургамал зонхилон тархана.



Зураг 30 Төсөл хэрэгжих талбай орчмын ургамлан нөмрөгийн хэв шинж

Тухайн төслийн талбайн орчны газарт зонхилогч ургамлууд болох баглуур-бударганат ургамлын бүлгэмдэл үндсэндээ устсан, нэлэнхийдээ халцгай, барилга байгууламж, хад чулууны ёроол хавиар ургамалтай боловч дан шарилж, хааяа хэсэгхэн газар баглуур, бударгана цөөн тохиолдоно.

Хүснэгт 9 Төслийн талбай орчмын ургамлын бүлгэмдэл, төлөв байдал


Ургамлын бүлгэмдэл	Төлөв байдал	Талхагдлын зэрэг
Чулуурхаг баглуурт, баглуур-бударганат	Бага сөөгтэй	Дунд зэрэг

Ихэвчлэн навчгүй баглуур-anabasis aphylla L, бор бударгана-salsola passerina Bunge, божмог шарилж-artemisia anethifolia Web ex Stechm, шүлхий шарилж- artemisia pectinata Pall, ямаан шарилж-artemisia scorotia тааралдана.

## 2.7 Тусгай хамгаалалттай газар нутаг

Өмнөговь аймагт улсын тусгай хамгаалалттай газар дөрөв бий. Үүнд, Говийн Бага дархан цаазат газар, Говь гурван сайхан байгалийн цогцолборт газар, Тост тосон бумбын нурууны байгалийн нөөц газар, Загийн усны тусгай хамгаалалттай газар багтдаг. Харин 2023 онд шинээр Дэмчигийн хийд, Загийн тойром, Балгасын улаан нуур, Говь гурван сайхан ойролцоох газруудыг улсын тусгай хамгаалалтад авахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас төлөвлөсөн.

Ханбогд сумын нутагт Говийн Бага дархан цаазат газрын “Б” хэсэг хамаарагдах бөгөөд “Пүшинмон” ХХК-ийн хэрэгжүүлж буй Гаалийн хяналтын талбай төслийн талбай нь Говийн Бага дархан цаазат газрын “Б” хэсгийн “Орчны бүс”-д багтаж байна.




Зураг 31 Төсөл хэрэгжих талбайн орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутаг

**Говийн Бага дархан цаазат газар:** Монголын зүүн өмнөд говийн үндсэн хэв шинжийг төлөөлсөн, байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан, дэлхийд ховордсон амьтад болох хулан, хар сүүлтийн гол байршил нутаг бөгөөд Монголын говийн байгалийн иж бүрдэл, ландшафтын өвөрмөц төрхийг хамгаалах зорилгоор нь УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор Говийн Бага дархан цаазат газар байгуулагджээ. Энэхүү дархан цаазат газар нь А, Б гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд нийтдээ 1.8 сая га талбай эзэлдэг. Өмнөговь аймгийн Номгон, Баян Овоо, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт оршино.

**Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг:** Төсөл хэрэгжих талбай нь “Аймгийн урд талын сумдын улсын хил дагуу Ханбогд” нэртэй Аймгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалтай, “Галбын говь” /Сумын/ тусгай хамгаалалттай газар нутгаас 11.11 км,

“Дайчингийн говь, Хонгорын овоо, Оройн худгийн зоо” нэртэй /Сумын/ тусгай хамгаалалттай газар нутгаас 13.1 км-ийн зайд оршиж байна.




Зураг 32 Төсөл хэрэгжих талбай орчмын Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

## 2.8 Түүх, соёлын өв

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг нь Агуйтын хийдийн туурь, Байшин цавын палеонтологийн дурсгалт газар, Баян хөөврийн хүн чулуун хөшөө, Далайн дуулга уулын хадны зураг, Дэмчигийн хийд, Жавхлант хайрхан хадны зураг, Зүрх уулын чулуу олборлож байсан газар, Зүүн хацавчийн хадны зураг, Мангасын хүрээ хэмээх эртний хэрэм, Үрэлбэгийн палеонтологийн дурсгалт газар, Хуурай цавын палеонтологийн дурсгалт газар, Хүрдэт агуйн бичээс, Цогцолын хийд, Шийр хайрхан хадны зураг зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудтай.

“Пүшинмон” ХХК-ийн хэрэгжүүлж буй Гаалийн хяналтын талбай төслийн талбай байрлах Цагаан хад суурьшлын бүстэй хамгийн ойр байрлах түүх, соёлын дурсгал нь Гурван зээрдийн агуй, Мангасын хүрээ хэмээх эртний хэрэм байна. Төслийн талбай нь дээрх түүх, соёлын дурсгалт газруудаас хол байрших тул ямар нэгэн шууд нөлөөлөл байхгүй болно.

**Мангасын хүрээ хэмээх эртний хэрэм:** Сумын төвөөс зүүн өмнө зүгт 75 орчим км зайд 135x140 м хэмжээтэй дөрвөлжин шороон далантай, түүний гадуур 600 м хэмжээтэй дугуй далан бүхий эртний хэрмийн үлдэгдэл бий. Энэ орчмоос төмөр шилбэт хүрэл зэв, ширмэн сүх, ваар савны хагархай зэрэг олддог бөгөөд судлаачид Хүннү гүрний үед хамаарна хэмээн үздэг байна.



Зураг 33 Ханбогд сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын байршил

## 2.9 Нийгэм, эдийн засаг

Тус сум нь 1924 онд Галба сум нэртэйгээр Хадан хошуу гэх газарт анх үүсгэн байгуулагдсан. Үүнээс хойш олон удаа нүүдэллэж 1941 онд одоогийн Их булаг хэмээх газарт суурьшсан байна.

Ханбогд сум нь 15,151 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй, тус сум нь аймгийнхаа төвөөс 250 км зайтай. Монгол, Хятадын хил дээр орших тус сум нь урд талаараа Хятад улстай хил залгаа Гашуун сухайт боомттой. Баруун талаараа Баян-Овоо сум, Зүүн талаараа Дорноговийн Хатанбулаг, Мандах сумтай, зүүн хойд талаараа Манлай сумтай хил залгаа. Засаг захиргааны анхан шатны нэгж болох Жавхлант, Гавилууд, Номгон, Баян, Хайрхан гэсэн 5 багтай.

Ханбогд суманд Онцгой байдлын Гал түймэр унтраах, аврах 66-р анги, 350, 160 хүний суудалтай соёлын төв, Нийгмийн даатгалын хэлтэс, Цагдаагийн тасаг, 50 ортой сум дундын эмнэлэг, Сум дундын шүүх, Сум дундын 1-р прокурор, Хандизель, Ханбогд хот тохижилт зэрэг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, ХААН банк, Хадгаламж банк, Хас банк, Голомт банк, Капитрон банкны салбарууд үйл ажиллагаа явуулж байна.

Хувийн хэвшлийн 300 гаруй аж ахуйн нэгж, 60 гаруй дэлгүүр, супермаркет, 30 орчим цайны газар, ресторан, зочид буудал үйл ажиллагаа явуулж байна. Ханбогд сум бизнес эрхлэх таатай нөхцөлтэй гэж хэлж болно.

Тус суманд мал аж ахуй, уул уурхайг хослуулахын зэрэгцээ аялал жуулчлал хөгжих таатай нөхцөл бүрдсэн нутаг юм. Иймээс хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлууд хийгдэж байна. Сумын нутаг дэвсгэрт Оюутолгойн орд, түүнчлэн зүүн хойд талдаа Цагаан суваргын алт, зэсийн орд, зүүн тийш Хармагтайн орд, хойд талдаа Цогт-Цэцийн Таван толгойн уурхай гээд Монгол орны томоохон хөрөнгө оруулагч, төсөв санхүү бүрдүүлэгч том уул уурхайнуудын яг гол, төв хэсэгт нь байрладаг.

**Эрүүл мэнд :** Өмнөговь аймаг нь 128 эрүүл мэндийн төвтэй, Ханбогд сум 1 эрүүл мэндийн төвтэй бөгөөд сумынхаа 1155 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг хүргэж байна.

**Хүн ам:** Өмнөговь аймаг нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 26075 өрхийн 78763 хүн амтай бол Ханбогд сум нь 2277 өрхийн 9533 хүн амтай, Хайрхан баг нь 159 өрхийн 779 хүн амтай байна. 2021 оноос 2024 онуудад Хайрхан багийн хүн ам, өрхийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 10 Ханбогд сумын хүн амын тоо /багаар/

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Өмнөговь	72943	73939	76153	78763
Ханбогд	8404	8533	8941	9533
Хайрхан	509	538	640	779

Хүснэгт 11 Өрхийн тоо

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Өмнөговь	23164	23712	25336	26075
Ханбогд	2116	2145	2193	2277
Хайрхан	110	112	138	159

**Малын тоо, толгой:** 2024 оны жилийн эцсийн байдлаар Ханбогд суманд малтай өрхийн тоо 690, 127543 тоо толгой мал бүртгэгдсэн 7517 адуу, 4689 үхэр, 29186 тэмээ, 34966 хонь, 51185 ямаа бүртгэгдсэн байна. Сумын хэмжээнд малын тоо толгой 2021-2024 онуудад буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 12 Малтай өрхийн тоо

Засаг захиргааны нэгж	Баг, хорооны код	2021 он	2022 он	2023 он	2024 он
Өмнөговь	346	8230	8170	7690	7540
Ханбогд	34631	740	720	700	690
Хайрхан	3463159	0	0	0	0

Хүснэгт 13 Малын тоо, /мян.төг/

Засаг захиргааны нэгж	Малын төрөл	2021 он	2022 он	2023 он	2024 он
Ханбогд сум	<b>Бүгд</b>	<b>192.904</b>	<b>208.328</b>	<b>164.176</b>	<b>127.543</b>
	Адуу	10.387	11.407	9.114	7.517
	Үхэр	7.56	8.403	6.186	4.689
	Тэмээ	33.089	34.42	33.252	29.186
	Хонь	54.275	58.565	45.669	34.966
	Ямаа	87.593	95.533	69.955	51.185
Хайрхан баг	<b>Бүгд</b>	<b>1.391</b>	<b>1.176</b>	<b>0.97</b>	<b>0.738</b>
	Адуу	0	0	0	0.017
	Үхэр	0.045	0.051	0.063	0
	Тэмээ	0.015	0.016	0.017	0.041
	Хонь	0.6	0.513	0.362	0.233
	Ямаа	0.731	0.596	0.528	0.447

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 3.1 Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл

“Пүшинмон” ХХК-ийн нүүрс ачиж буулгах, гаалийн хяналтын талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийн зүүн урд хэсэгт улсын хилээс хойш 20 гаруй км-т Цагаан хадын худгаас баруун хойш 3.5 км–т 40 га газар байрлана. “Гаалийн хяналтын талбай” төслийн орчимд хийсэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хүрээн дэх судалгаагаар төслийн нөлөөллийг 2 бүсээр хуваан авч үзлээ. Үүнд :

- Төслийн талбайгаас 50 м зайд шууд нөлөөллийн бүс
- Төслийн талбайгаас 100, 200 м зайд шууд бус нөлөөллийн бүсийг авч үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн эзэмшлийн талбайн ойр орчмын 200 м хүртэлх талбайд хяналт тавьж ажиллах шаардлагатай.

### 3.2 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Тус төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд нөлөөлөх нөлөөлөл харьцангуй бага.

- Гадаад дотоод тээвэрлэлт хийх автозам, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас газрын гадаргад /40 га талбайд/ эвдрэл үүснэ.
- Төслийн талбайн хатуу хог хаягдлыг зайлуулах хогийн цэг, нүүрсний тоос, хаягдал, шатах тослох материалын хаягдлаас газрын гадаргуу бохирдож болзошгүй.

### 3.3 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

“Гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагаанаас тухайн бүс нутгийн агаарын чанарт нөлөөлөх гол нөлөөллүүдэд төслийн хүрээнд явагдах үйл ажиллагаа болох нүүрс тээвэрлэлт, гаалийн буулгалт, ачилт хийх үеийн ажилтай холбоотойгоор агаарт босох тоос шороо, хүнд даацын машин механизмууд автомашины ялгарах хорт утаа зэрэг орох ба эдгээр нь төслийн нутаг дэвсгэрийн ойр орчмын агаарын чанарыг муутгаж, орчны тоосжилтыг ихэсгэх магадлалтай.

### 3.4 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны явцад усан орчинд дараах нөлөөллийг үзүүлж болзошгүй.

- Төсөл хэрэгжих явцад гүний худгаас зөөврөөр ус авч ашиглах учир газрын доорх усны нөөцөд тодорхой хэмжээгээр шууд нөлөөлнө.
- Төслийн талбай, түүний орчим гол, горхи, булаг шанд, хаврын шар ус, хур борооны үерийн усаар тэжээгддэг хуурай сайр байхгүй учир гадаргын усны чанар болоод нөөцөд төслийн үйл ажиллагаанаас шууд нөлөөлөл үзүүлэхгүй.
- Тээврийн хэрэгслээс дизель түлш алдагдах, ослын үед нефть бүтээгдэхүүнийг үлэмж их алдвал хөрс, хэвгий газраар дамжин газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

### 3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн талбайд тархах Цөлийн бор саарал хөрс нь гаднын нөлөөгөөр элэгдэлд маш хурдан орж үржил шимээ хурдан алддаг бөгөөд байгалийн аясаар дахин сэргэх нөхцөл туйлын хомс байдгийг эрдэмтэд тогтоосон байдаг. Төсөл хэрэгжих орчны хөрс нь байгалийн хүчин зүйлээс гадна тээврийн хэрэгслийн нөлөөгөөр олон салаа зам үүсэж тэдгээрээс шалтгаалан үржил шим, унаган бүтцээ алдан салхинд хийсэх замаар элэгдэлд орсон байдал ажиглагдаж байна. Хөрсөн бүрхэвчинд төслөөс дараах нөлөөллүүдийг үзүүлнэ. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн улмаас хөрс талхлагдах
- Барилга, байгууламжид өртөх

- Нүүрсний тоос, бүтэц нь алдагдсан үхмэл шороонд дарагдах гм.
- Техник машин механизмын түлш шатахуун, тос тосолгооны материал зэргийг алдаж асгаснаас хөрс бохирдох

### 3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

- Тоосжилт нь ургамлын фотосинтезийн процесст саад учруулж өсөлт хөгжлийг зогсоох.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалан тэр орчмын газар талхагдалд өртөж ургамлан нөмрөг устгах

Төсөл хэрэгжих явцад ашиглалтын талбайд нийтдээ 40 га талбайг ашиглах бөгөөд тээвэрлэлтийн явц, тоосжилтоос ургамал талхагдалд орох, ургамлын аймгийн зүйлийн бүрдэл цөөрч үгүй болох, өөрчлөгдөх зэргээр тухайн газарт экосистемийн өөрчлөлт гарах сөрөг нөлөөтэй

### 3.7 Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Төслөөс тухайн орчны нийгэм, эдийн засагт дараах байдлаар нөлөөлнө.

- Төслийн талбайд оршин суугчид үгүй учир нутгийн иргэдийн газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөхгүй, нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэхгүй.
- Төсөл хэрэгжсэнээр нутгийн иргэд тодорхой хэмжээнд ажлын байраар хангагдана.
- Хамгийн ойр орших суурин газар нөлөөллийн бүсийн гадна байгаа тул сөрөг нөлөөлөлд өртөхгүй.
- Уг төслийг хэрэгжүүлснээр нийт 28 хүний ажлын байр бий болно.

Төсөл хэрэгжих ажлын үед машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

### 4.1 Зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

“Пүшинмон” ХХК-ийн “Гаалийн хяналтын талбай” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтын дагуу “Бурхан Буудай Бүтээмж” ХХК боловсруулав.

Тус төсөл хэрэгжүүлэгч нь 2026 оны байгаль хамгаалах төлөвлөгөөнд 9,265,000.0 /есөн сая хоёр зуун жаран таван мянга/ төгрөг төсөвлөсөн бөгөөд үүний 50% болох 4,632,000.0 /дөрвөн сая зургаан зуун гучин хоёр мянга/ төгрөгийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний барьцаа болгож Ханбогд сумын “Байгаль орчны нөхөн сэргээлтийн данс”-д байршуулав.

### 4.2 Хамрах хүрээ:

Төслийн хувьд хамрах хүрээ нь өөрийн төсөл хэрэгжих газар талбайд төдийгүй, харьяа нутаг дэвсгэрийн ус, хөрс, агаар орчин хамаарна.

*Хүснэгт 14 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл дүн 2026 он*

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Тухайн жилийн төсөв /мян.тог/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,840.0
2	Нөхөн сэргээлт, зүлэгжүүлэх арга хэмжээ	1,875.0
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	900.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,440.0
7	Удирдлага зохион байгууллалт ба осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	950.0
8	БОМТ-ыг орон нутагт тайлагнах төлөвлөгөө	-
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	260.0
<b>Нийт</b>		<b>9,265.0</b>

**ТАВДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 15 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Төлөвлөсөн, мян.төг	Тайлбар
	1	2	3	5	6	7	8
1	Агаарын чанар	Хог хаягдал шатааж агаар бохирдуулахгүй байх.	Төслийн хүрээнд	-	-	-	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2		Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж ажиллах	Төслийн хүрээнд	-	-	-	
3		Машин, өөрөө явах хэрэгслийг авто үзлэгт оруулах, үзлэгт тэнцсэн байх.	Төслийн хүрээнд	65.0	24.0	1,560.0	
4		Орчны тоосжилт хамгийн бага байх нөхцөл бүрдүүлж ажиллах. /Замын усалгаа хийх, сайжруулсан хучилт хийх/	Төслийн хүрээнд	-	-	-	
5	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Зорчих хэсэг болон явган хүний зам засах, тэмдэгжүүлэх.	Төслийн хүрээнд	1,500.0	1.0	1,500.0	MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
6		Тээврийн замын маршрут баталсан байх, маршрутын дагуу тээвэрлэлт хийх.	Төслийн хүрээнд	-	нэг удаа	-	
7		Замыг байнга засварлаж, тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах,	Төслийн хүрээнд	260	3	780.0	
8		Төслийн талбайн гадна, дотор талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх	Төслийн хүрээнд	-	тухай бүр	-	
9	Усны чанар	Хөрсний бохирдлоос сэргийлж нүхэн жорлон хэрэглэхгүй байх.	Төслийн хүрээнд	-	тухай бүр	-	Усны тухай хууль; тус хуулийн 24, 28 дугаар зүйл.
<b>Нийт /мян/төг/</b>						<b>3,840.0</b>	

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 16 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу хийх арга хэмжээ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш/	Нэгжийн зардал, мян/төг	Төлөвлөсөн, мян.төг	Тайлбар
1	2	3	4	5	6	7	
1	Нөхөн сэргээлт	Цөлжилтөөс сэргийлж төслийн талбай орчныг зүлэгжүүлэх	удаа	1	750	750.0	<i>MNS 5914-2008- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт. MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага</i>
2		“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, Өмнөговь аймгийн байгаль орчны газрын чиглүүлгээр заасан талбайд мод тарих	ш	100	11.25	1,125.0	
<b>Нийт</b>						<b>1,875.0</b>	

**ДОЛООДУГААР БҮЛЭГ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тус төсөл нь уул уурхайн төсөл биш учраас төслийн хүрээнд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө тусгагдаагүй. Харин төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс төслийн талбайг ногоон байгууламжтай болгох, “Тэрбум мод хөтөлбөр”-ийн хүрээнд мод тарихаар төлөвлөсөн. Үүнийг нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгасан болно.

**НАЙМДУГААР БҮЛЭГ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн үйл ажиллагаанаас хамаарсан нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох шаардлагагүй учраас төлөвлөгөө хийх шаардлагагүй.

Хүснэгт 17 Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	-	-	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>		-	-	-	-	-	-	-

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

*Хүснэгт 18 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ*

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	-	-	-	-	-	-	-
2.	Палеонтологийн дурсгал	-	-	-	-	-	-	-

**АРАВДУГААР БҮЛЭГ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт 19 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ*

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Төлөвлөсөн, мян.төг	Тайлбар
	1	2	3	4	5	6	7
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Галын аюулгүй байдал хангаж ажиллах	Төслийн хүрээнд	1	-	-	<i>Гамигаас хамгаалах тухай хууль, 27.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай.</i>
2		Ажилтан албан хаагч нарыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслээр хангаж ажиллах	Ажилчдад	тухай бүр	-	-	
3		Бүх ажилтанд ХАБЭА-ын сургалт хийх	Ажилчдад	1	900	900.0	
4		Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийлгэх	Төслийн хүрээнд	1	-	-	
<b>Нийт /мян/төг/</b>						<b>900.0</b>	

**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт 20 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ*

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Төлөвлөсөн, мян.төг	Тайлбар	
1	2	3	4	5	6	7	8		
1	Энгийн хог хаягдал	Хог хаягдлыг үүсгэвэр дээр нь ангилах битүүмжлэлтэй хогийн савтай болох.	Төсөл хэрэгжих талбай	-	-	-	ҮА зардлаар	<i>Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,</i>	
2		Ахуйн хатуу хог хаягдал зайлуулах гэрээний дагуу тухай бүрд ачин зайлуулж байх.		удаа	120	6	720.0		
3		Ариутгал цэвэрлэгээний ажлыг сар болгон графикийн дагуу хийх.		удаа	-	сар бүр	ҮА зардлаар		
4		Ахуйн бохирыг тухай бүр соруулах, ачин зайлуулах.		удаа	120	6	720.0		
5	Аюултай хог хаягдал	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялгаж, цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх.		кг	-	-	ҮА зардлаар		<i>Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент UCS 1701A</i>
6		Авто машины засвараас гарах тос масло, төмөр бусад хогийн энгийн хог хаягдлаас ангид хадгалж, дахин боловсруулах аж ахуй нэгжид эрх шилжүүлэн өгөх.		кг	-	-	ҮА зардлаар		
Нийт /мян/төг/							<b>1,440.0</b>		

## АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Пүшинмон” ХХК-иас хэрэгжүүлж байгаа төсөл байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хэмжих, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг нэгтгэн тухайн жилийн байгаль орчны менежментийн биелэлтийн тайланд хавсарган тайлагнана.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэргийг мэргэжлийн байгууллагаар хийлгэхэд анхаарч, төслийн байгаль орчны холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх шаардлагатай.

Хүснэгт 21 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Төлөвлөсөн, мян.төг	Тайлбар
1	2	3	4	5	8	
1.1	Агаарын тоосны (CO <sub>2</sub> , PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> , HCHO) шинжилгээг төслийн талбайд хийх. /Агаарын чанарын хяналт хийх зөврийн багажаар/	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 3 цэг сонгох.	1 цэгээс жилд 2 удаа	Жилд 2 удаа	-	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, /Цэг.1 - Нүүрс ачиж буулгах талбай; Цэг.2 - Оффисын талбайн гол хэсэх; Цэг.3 - Ажилтны амралтын байрны дотор;/
2.1	Усны шинжилгээ-Ерөнхий химийн үзүүлэлт	Ундны уснаас дээжлэх	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	130.0	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2005
2.2	Усны шинжилгээ-Хүнд металл					
3.1	Хөрсний шинжилгээ – Агро хими	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох.	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	130.0	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 5850:2029 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3.2	Хөрсний шинжилгээ – Хүнд металл /6 үзүүлэлт/					
<b>Нийт</b>					<b>260.0</b>	

**АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Төлөвлөсөн, мян.төг	Тайлбар
1	Үүсэж болзошгүй гэнэтийн осол аваар, галын аюул, цахилгаан техникийн гэмтэл.	Гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн хэмжээнд	-	-
2	Үүсэж болзошгүй гэнэтийн осол аваар, галын аюул, цахилгаан техникийн гэмтэл.	Компанийн удирдлагуудыг "ХАБЭА сургалт - компанийн удирдлагад чиглэсэн" сургалтад хамруулах.	Удирдлагууд	950.0	-

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Төлөвлөсөн, мян.төг	Тайлбар
3	Менежментийн төлөвлөгөө хэрэгжилт алдагдах	Аймгийн БОАЖ-ын газартай хамтран “Байгаль хамгаалах өдөр”-ийг хамтран зохион байгуулах	Төслийн хүрээнд	-	-
4	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Байгаль орчин хамгаалах, иргэд олон нийтэд таниулах ажилд Ханбогд сумын Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллах. /тамгын газраас чиглэл авах/	Төслийн хүрээнд	-	-
<b>Нийт зардал /мян/төг/</b>				<b>950.0</b>	

**АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ  
 НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Өмнөговь аймгийн байгаль орчны газарт	Цаасан тайлан	БОМТ-ний хэрэгжилт болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийн тайлан	11-р сарын 01		Байгаль орчны менежер	--
2	БОУАӨЯ-д	Цахим тайлан	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийн тайлан	11-р сарын 01	--	Байгаль орчны менежер	--
	<b>Нийт</b>				-		